



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн 2021-2022 оны хөрөнгө оруулалтаар “Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхийн цахилгаан хангамжийн техникийн боломжийг сайжруулах” багц-5 хүрээнд бий болсон 5 нэрийн, нийт 163,001,095.00 (нэг зуун жаран гурван сая нэг мянга ерэн таван) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Тавинбэх, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Р.Дагдан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх, бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132004633
7-г huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны 03 дугаар сарын-ны өдрийн
 дугаар тогтоолын хавсралт

"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд
 бүртгэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хүчин чадал			Балансын үнэ (төгрөг)
			Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Биет хэмжээ	
1	АТП-2562 орчмын хүчдэлийн уналттай болон цахилгаангүй айл өрхүүдийн цахилгаан хангамж	2022	ш	1	6/0.4кВ-ын 250кВА АТП өргөтгөл 1ш, 0.4кВ-ын ЦДАШ 0.441км Тоолуур 18 ш	23,099,706.00
2	АТП-0776 орчмын хүчдэлийн уналттай болон цахилгаангүй айл өрхүүдийн цахилгаан хангамж	2022	ш	1	6/0.4кВ-ын 250кВА АТП өргөтгөл 1ш, 0.4кВ-ын ЦДАШ 0.554км Тоолуур 21 ш	26,551,988.69
3	АТП-4418 орчмын хүчдэлийн уналттай болон цахилгаангүй айл өрхүүдийн цахилгаан хангамж	2022	ш	1	0.4кВ-ын ЦДАШ 0.430км Тоолуур 15 ш	14,294,106.32
4	АТП-6912 орчмын хүчдэлийн уналттай болон цахилгаангүй айл өрхүүдийн цахилгаан хангамж	2022	ш	1	6/0.4кВ-ын 250кВА АТП 1ш, 0.4кВ-ын ЦДАШ 0.322км Тоолуур 15 ш	31,340,363.00
5	АТП-6911 орчмын хүчдэлийн уналттай болон цахилгаангүй айл өрхүүдийн цахилгаан хангамж	2022	ш	1	6/0.4кВ-ын 250кВА АТП 1ш, 6кВ-ын ЦДКШ 269м, 0.4кВ-ын ЦДАШ 1897км Тоолуур 87 ш	67,714,930.99
НИЙТ ДҮН						163,001,095.00 (нэг зуун жаран гурван сая нэг мянга ерэн тав)